



Цагаан Лянхуа Цэцгийн Судар 4-р бүлэг

The World of the Lotus Sutra

Шаарийбуу Буддад хүрэх баталгаа авч, Шагжамүни нь “Гурван тэрэг ба шатаж буй байшингийн үлгэр”-ийн домогоор сургаалыг ойлгомжтой тайлбарласан тул тэнд байсан Дөрвөн Агуу Шёмон нар ихэд сэтгэл хөдөлж, сургаалын нандин мөн чанарыг улам мэдэрсэн бололтой байв. Тэд Шагжамүнид мөргөөд ингэж асуув:

“Шагжамүни та аль дээр үеэс бид нарт сургаалыг зааж ирсэн боловч бид сургаалыг буруу ойлгож, зөвхөн өөрсдийнхөө өчүүхэн гэгээрийг л зорьж байсан. Бид бол Буддын үр хүүхэд бөгөөд буддын гэгээрэлд хүрч чадна гэдгийг мэдэлгүй бодисадвагийн үйлийг үл тоож ирсэн билээ. Бидний анд болох Шаарийбууд Будда болох баталгаа өгсөн тул маш баяртай байна. Мөн бид Шагжамүни таны сургаалыг ийнхүү хүлээж авлаа. Үүнийг жишээ үлгэрээр тайлбарлая” гээд ахлагч нь яриагаа эхлэв:

“Бага насандаа нэгэн баяны хүү гэрээсээ зайлан олон гадаад орноор тэнэж, ядуу зовлонтой амьдрал туулсаны эцэст нэг өдөр санамсаргүй эцгийнхээ амьдарч буй ордонд хүрж иржээ. Өөрийгөө ордонд баяны хүү гэдгийг мэдэлгүй хүү тэр ордонд цэвэрлэгчийн ажил хийхээр болжээ. Хүү 20 жил үнэнчээр ажиллаж, баяны итгэлийг эзэмшиж чадсан тул түүний хөрөнгийг хянах үүрэгтэй болов. Баян өөрийгөө удахгүй нас эцэслэх нь гэж мэдмэгц бүх хамаатан садан, Улсын хаан ба сайд


нарыг цуглуулж тэдний дэргэд уг хүүг өөрийнх нь төрсөн хүү байсан юм гэдгийг нээн яриад хамаг эд хөрөнгөө хүүдээ үлдээхээр болов. Хүү баяны үгийг сонсоод тэр түүний эцэг байсан гэдэгт маш их баярлаж, бас санамсаргүй орж ирсэн эд хөрөнгөд ч баярлан гайхав.

Энэ үлгэрийн баян бол Будда, эцгийгээ мэдэхгүй хүү нь бол яг л бид нар шиг Буддагийн хүүхэд мөн” гээд тэрээр яриагаа дуусгав.

Тэгээд Дөрвөн Агуу Шёмон нар Шагжамүнид хандаж ингэж хэлэв:

“Бид өчүүхэн зорилгын төлөө байж, бодисадвагийн үйлийн замыг үл тоож ирсэн билээ. Будда үүнийг мэддэг байсан тул бид нарын төлөө янз бүрийн уран арга хэрэглэж, Их Хөлөгний сургаалд хүргэж өглөө”.

Тэд ийнхүү Буддагийн буянд юу ч хийсэн ч хариулж барашгүй гэсэн гүн талархалын сэтгэлээр дүүрэн болов.



Special Topics

Лидерын сургалт 2011 нээгдлээ

7 сарын 11-с 7 сарын 23 хүртэл Төв дээр лидерын сургалтын семинар явагдаж, 8 нийгэмлэг, 13 салбараас 3 дахь ба 4 дахь үеийн 33 оюутан залуучууд хүрэлцэн иржээ. Өдөр бүр үргэжлэх 30 хэм гаруй халуунд залуучууд төрөл бүрийн сургалтанд идэвхтэй оролцлоо.

Мөн сургалтын сүүлийн өдөр Кошё хатагтайгийн “Үүсгэн Байгуулагчаас суралцах нь” гэсэн сэдэвтэй лекци явагдав. Үүсгэн Байгуулагчийн үзэл бодлын талаар олон сайхан сургамж сонсч, бүгд талархалын сэтгэлээр дүүрэн байв.

2 дахь жилдээ орсон оюутнууд дахин уулзсандаа бөөн баяр болж, анх ирсэн оюутнууд ч биеэ барилгүй

цагийг сайхан өнгөрөөж чаджээ. Салахад хэцүү байсан ч оролцсон залуучууд тус тусынхаа орон нутагтаа хариад сургаалын даяаны үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно гэдэгт баи итгэж байна.

3 дахь үеийн оюутнууд амжилттай төгссөнд баяр хүргэе. 4 дахь үеийн оюутнуудтайгаа дараа жил дахин уулзах болтугай.

Олон сайхан сэтгэгдэл үлдээсэнд талархан баярлаж байна.

Гараа хавсарган мөргөө



Сэтгэлээ ариусгая

РКК-ийн Ерөнхийлөгч
Нивано Ничико

Судар унших нь

Бид бүгд “сэтгэлээ ариусгаж, хүнийхээ мөн чанараа хөгжүүлж, бусдыг баярлуулж чаддаг хүн болохсон” гэж хүсэн тэмүүлж амьдардаг.

Буддистуудын хувьд бид мэдээж хэрэг буддын сургаалыг суралцах ёстой гэсэн бодолтой байдаг. Гэвч бид сургаалыг барьж судлахгүй байсан ч өөрийнхөө өдөр бүрийнхээ амьдрал дээр сургаалаас суралцаж байдаг гэдгийг анзаарсан болов уу?

Өглөө, оройн судрын ном уншлага нь бидний нэгэн чухал үйл билээ. Зарим үед сэтгэл урваж, анхаарлаа төвлөрүүлэх хүсэл ч, чадал ч байдаггүй билээ. Тэгсэн ч тийм үед судраа чин сэтгэлээсээ уншихад буддын сургаалын үг зүрх сэтгэлд шингэн орж, сэтгэл ариусдаг билээ.

“Суралцана” гэдэг үг нь өөрөөр хэлбэл “дуурайна” гэсэн утгатай юм. Энэ утгаараа буддын сургаалыг сурна гэдэг нь Шагжамүниг дуурайж, түүний заасан үг, үйлдлийг давтан дуурайж хийнэ гэсэн үг билээ. Буддын сударт Шагжамүнигийн заасан үг, сургамж олноор орсон байдаг тул судрынхаа номоо уншсанаар бид Шагжамүнигаас дуурайн сурч байдаг юм.

Камакүра үеийн нэрт лам багш: “эрдэм суралцана гэдэг нь сэтгэлээ засна гэсэн үг” гэж хэлсний дагуу хүн суралцах үйлээр дамжин сэтгэлийнхээ буруу зөрүүг засаж, сэтгэлээ ариусгаж байх хэрэгтэй. Бас хичнээн их буддын судар ном уншсан ч тэдгээрийг өдөр бүрийнхээ амьдрал дээрээ хэрэгжүүлэхгүй бол утгагүй билээ.



Буддын Амьтай нэгэн амь

Тэгвэл сэтгэлээ ариусгана гэдэг нь юу вэ?
Дооген зэн-лам багш:” буддын сургаалыг суралцана гэдэг бол өөрийгөө мэдэж сурна гэсэн үг юм” гэж заасан билээ. Сэтгэлээ ариусгана гэдэг нь дээрхи үгийн дагуу “өөрийгөө мэдэж сурна” гэсэн үг юм.

Тэгвэл, ”өөрөө” гэдэг нь юу вэ?
Шууд хэлбэл, амьдралын эх үндэс бол нэг л байдаг бөгөөд амилан амь байдаг бүхий зүйлд бурханы мөн чанар байдаг юм. Энэ бол бидний үндсэн мөн чанар ба “өөрөө” гэсэн ухагдахууны мөн чанар юм. Мөн үүнийг мэдэж авах нь “өөрийгөө мэдэж сурна” гэсэн үг юм.

Будда бол нинжин сэтгэлтэй тул бид хүмүүс ч уг үндсэндээ бусдыг хайрлан өрөвдөх сэтгэлээр дүүрэн байх ёстой билээ.

Гэтэл бид үе үе хэт шунаж, санасны дагуу болохгүй бол уурлан бухимдаж, бусдыг муулан гоочилж, хувиа хичээдэг байдаг. Ингэснээр бусадтай мөргөлдөж, өөрөө л зовж бухимддаг билээ. Тийм учраас л бид Буддагаас суралцаж, ”өөрийнхөө жинхэнэ мөн чанараа” олохын тулд хичээн зүтгэж байдаг юм.

Судраа дуулан уншсанаар бид өөрсдийгөө хүний хувьд зөв авч явахын талаар суралцдаг байна. Гэсэн ч хүний сэтгэлийг татаж, сэтгэлийн тэжээл өгөх ном зөвхөн судраар хэмжигдэхгүй нь мэдээж. Заим

хүмүүс христосын шашны Библи уншиж, зарим нь исламын судар уншиж, зарим нь олон нийтэд түгээгдсэн зураган ном уншиэ бие сэтгэлээ тайвшруулан ариусгадаг байна.

Би бол буддын судар ба бусад ном хэвлэл уншаад сэтгэлд хоногшсон үгийг хуулан бичлэг. Залуугаасаа л тэгээд сурчихсан юм.

Судар уншиж, сэтгэлээ ариусгана гэдэг нь зарим хүмүүст хэцүүтэй зүйл мэт санагдаж магадгүй. Гэвч хамгийн гол зүйл бол хүнийг хайрлан өрөвдөж чаддаг дулаахан сэтгэлтэй хүн болох явдал юм. Зовж ядарсан хүнд чин сэтгэлээсээ эелдэг хандаж, гараа сунган тусалж чаддаг хүн болно гэдэг нь сэтгэлээ ариусгана гэсэн утга юм. Энэ бол бидний сургаалын хийх ёстой хамгийн эхний үйлдэл юм.

“Косэй” 2011 оны 8 сарын дугаараас
Translated by Kosei Publishing Company



Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

РКК-ын дараах үеийн ерөнхийлөгч Нивано Коошо багш

Хүн бүрийн туяа

Хүү маань мөлхөж сурсан үед 9 настай,7 настай,4 настай бяцхан эгч нар нь “нааш ир,нааш ир” гэж дуудан тоголдог байв.Хариуцлагатай сүрхий том эгч чинь дүүгээ амандаа хийж болохгүй юмнаас зайлуулж,толгойгоо энд тэнд мөргөхвий гэж сайн хардаг байв.Тайван ааштай дунд эгч чинь дүүгийнхээ эвийг олж тоглохдоо сайн байв.Дүүгийнхээ сонирхолыг нь татаж,инээдийг нь хүргэж хамт инээмсэглэн тоглох нь их байв. Гэтэл “шинэхэн эгч” болсон бага охин маань дүүдээ байнга л “энэ бол болохгүй”, “тэр бол чамд ахдах учир би хийгээд өгье” гэх мэтээр дүүгийнхээ авах гэж байгаа юмыг түрүүлээд булаачихдаг байв.Уг нь дүүгээ харж байгаа санаатай байсан боловч дүү нь яваандаа түүнийг тоохоо болиод нөгөө хоёр эгч рүүгээ л тэмүүлдэг болов.

Охин маань ч “би дүүтэйгээ тоголмоор байхад тэр намайг ерөөсөө тоохгүй юм.надад дургүй юм шиг байна” гэж гоморхож эхэлсэн юм.Тийм үед би бусад охидыг байхгүй үеийг харж байгаад “нөгөө аргаа” хэрэглэдэг байв.”Юу гэж дээ.Түрүүн ээж нь дүүтэй чинь хоёюулхнаа байхад дүү чинь чамд хамгийн их хайртай гэж хэлж байсан шүү” гэж хэлэхэд охин маань:

“Нээрээ юу?” гэж хэсэгхэн маш их баярласан царай үзүүлснээ дүүгийнхээ байдлыг эргэн санасан бололтой “Үнэн болов уу даа?” гэж гайхан асууж байв.Яг тэр үед дунд охин маань орж ирээд: “нээрээ шүү,надад ч тэгж хэлж байсан.Чамд хамгийн их хайртай гэж.Дандаа тоголж өгдөг учраас.Тиймээс чи дүүтэйгээ дахиад тоглоорой доо” гэж хэлсэн юм.

Би маш их гайхсан билээ.7 настай хүүхдийн үг гэхэд итгэмээргүй байв.Хэн ч харсан ч тэр дүүтэйгээ хамгийн их эвлэг харьцаж чаддаг,дүү нь ч түүнд хамгийн дуртай очдог гэдгийг охин маань өөрөө ч сайн мэддэг байсан.”Эрэгтэй дүү бол мэдээж хэрэг надад хамгийн хайртай шүү дээ” гэж хэлсэн ч хэн ч эсэргүүцэхгүй билээ.гэвч охин маань эмэгтэй дүүгийнхээ сэтгэлийг бас ээжийнхээ сэтгэлийг уншиж,зелдэг үг хэлж өгсөн



Нивано Коошо

Нивано Ничико ерөнхийлөгчийн том охин болж Токиод мэндэлсэн. Хуулч мэргэжлээр их сургуулиа дүүргэсний дараагаар РКК-ын удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Такурин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа Косей Кайгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашинтнуудын хамтын ажиллагаан дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн дараа үеийн ерөнхийлөгчөөр сонгогдох дияаны үйлээ үргэлжлүүлсээр байгаа. Мүнэхиротой гэрлэсэн бөгөөд нэг хүү, гурван охины ээж болсон.



билээ.

Сүрхий сайн том эгч ба эрх дүүгийн хооронд дунд охин маань томоотой дуугай зантай боловч нэг харахад л дандаа инээмсэглэн зогсож байдаг юм. Дунд охин учраас би ч заримдаа сайн харалгүй байдаг учраас охин маань сургуулийнхаа юмаа мартдаг, ширээ нь дандаа заваан байдаг гээд санаа зовдог байсан юм.

Гэвч том охин маань болохоор цэв цэвэрхэн цэмцэлсэн ширээндээ хүний гар хүрэхийг ч хориглодог бол дунд охин маань хичнээн заваан байсан ч дүү нар нь юмыг нь оролдоход “зүгээр, зүгээр. Ав ав” гэдэг билээ. Дээрхи үгийг ч би түүнд заасан үг биш учраас надаас бол яасан ч гарахгүй үг билээ. Эгчийнхээ үгийг сонсоод сэтгэл нь тэнийсэн бага охин маань “өө, тийм үү? За, тэгвэл би дүүтэйгээ тоголлоо” гээд гүйгээд яваад өгөв. Дунд охиноо хартал тэр инээмсэглэн зогсож байв. “Миний охин үнэхээр эелдэг сэтгэлтэй юм аа” гээд түүнийг тэврэн үнсэхэд охин маань жаахан ичсэн ч их л баяртайгаар толгойгоо налан тэврэв.

Сэтгэлийн эх орон

Танпабэй хоза
Деби Вомэро

Би Америкийн католик шашинтай сэхээтэн гэр бүлд төрж өссөн билээ. Бидний шашинд хандах хандлага маш хялбар юм. Ням гаригийн өглөө сүмийн цуглаанд оролцоод дараагаар нь хааяа ганц хоёр хөгшин хамаатныхаа гэрт очиж уулздаг байв. Үүнээс бусад зүйлээр бол би бусад найз нөхөдтэйгээ ялгаагүй л амьдралтай байсан.

Арван хэдэн настай болмогц католик шашин нь надад яршигтай санагдаж эхэлсэн. Миний хувьд зөвхөн ням гаригийн өглөө шүтдэг шашин бол сонин санагддаг байв. Зуршил мэт энэ ням гаригийн өглөөний дараах долоо хоног манай гэр бүл шашин, сургаалын талаар огт ярилцадаггүй байв. Эцэг эх маань ч надад яваандаа ням гаригийн өглөө биш орой нь өөрөө унаагаа бариад сүм үрүү явахыг зөвшөөрсөн билээ. Гэсэн ч би машинаараа сүм хүртэл оччихоод оролгүйгээр цуглаан дуусахыг машин дотроо радио сонсонгоо хүлээдэг байлаа. Гэртээ хариад эцэг эхдээ бол мэдээж хэрэг цуглаанд оролцоод ирлээ гэж худлаа ярьдаг байв.

Гэрээсээ тусгаарлаад ганцаараа амьдарч эхлэнгүүтээ католик шашнаас гарчихсан юм. Олон жил төөрөгдөн бухимдсаны эцэст хүн буянтай хүн болохын тулд заавал шашны байгууллагад хамаарагдах ёсгүй гэдгийг

гэрийнхэндээ ч хатуу хэлдэг байв. Гэвч би 20 хэдэн нас хүрмэгц өөрийгөө ертөнцөд хандах хандлагаараа тун өрөөсгөл, зөрүүд гэдгээ мэдэж эхэлсэн. Хүмүүсийг сайн, муугаар нь ялгаж, шүүмжилдэг байсан тул олон ч холбоо харилцаа тасарсан билээ.

31-тэйд миний бие дахин дахин өвдөж, эмчээс олон дахин үргэжилдэг бие эрхтэнгийн хатууралтын өвчнөөр өвдсөнөө мэдэж авсан юм. Эмээр биеийн байдал жаахан тайвширсан ч би өвчнөөсөө бүрмөсөн салахсан гэж хүсдэг байв.

Тиймээс ч 40-чин хэд хүртэл байнга өвчнийхөө эмчилгээний талаар судалж хайдаг байлаа. Анх энэ өвчнөөр өвдөөд үзүүлсэн эмч маань миний яриаг сонсоод, хүний буруу үзэл бодлоос үүсэх үр дүнгээс болж хүний биенд “амар тайван дутсан байдал” үүсдэг гэж тайлбарласан билээ. Хүний сэтгэл, бие, сүнс бол хоорондоо нягт уялдаа холбоотой гэдгийг ч тайлбарлаж өгсөн билээ. Тэгээд миний өвчин бол би бусад хүмүүст их хүйтэн ханддаг байснаас үүссэн магадлагатай гэж оношилсон юм. Үүнийг сонсоод би маш их цочирдсон юм. Яагаад гэвэл энэ бол үнэн байсан юм.

Түүнээс хойш би ертөнцөд шүүмжлэгтэй хандахаа болье гэж шийдсэн. Өөрөө өөрийнхөө дотор өсгөж хөгжүүлж орхисон сэтгэлийн зовлонгоо сайвтар сонсож, учрыг нь олохыг зорив. Ийнхүү янз бүрийн байдлаар замаа хайж байтал буддын шашинтай учирсан юм. Нэгэн зэн-группэд элсэж хүн бүр хувь хувьдаа гэгээрлийг зорьсон ням гаригийн цуглаанд ч оролцдог байв. Тэгсэн ч энэхүү шашны цуглаан нь миний сэтгэлд нийцэлгүй жил хагасын дараа би энэ группээс гарсан юм. Дараагийн хэдэн жил би ганцаараа буддын шашинг судалж, туршиж ирсэн. Тэгээд би нийгэмд ямар нэгэн хувь нэмэр үзүүлэхсэн гэж бодож эхэлсэн юм. Үүний төлөө би уншиж бичиж сургадаг буяны байгууллагад бүртгүүлж, одоо ч энэхүү буяны ажлыг хийсэн хэвээр. Мөн би

амьтны эрхийг хүндэлж, мах идэхээ больсон юм.

Яваандаа надад сэтгэлийн дэмжлэг, тусалцаа хэрэг болоод би өөртөө таарах шинэ санга хайж эхлэв. Удалгүй би Танпа Бэй Вежитарианы хурал дээр РКК-ийн хүнтэй учирсан юм. Тэр эмэгтэй гишүүн маш идэвхтэй байсан тул би сангад оролцохыг шийдэв.

Анх РКК-ийн Танпа бэй Хоза дээр очиход тэндхийн дарга, гишүүд нар маш сайхан дулаан санагдсан юм. Энэ бүхэн нь Нэгэн Хөлгийн сургаалтай холбоотой гэдгийг мэдэрсэн тул очсон өдөртөө гишүүнээр элссэн юм. Би ийнхүү сэтгэлийнхээ эх орноо олсон юм. Би хозад анхнаас л дуртай болсон. Хоза дээр хүмүүс бие биенийхээ яриаг сайвтар сонсож, зөвлөгөө өгнө. Өөрийнхөө дутагдалыг ний нуугүй ярьж чаддаг болно. Салбарын дарга Ник Озна ба бусад гишүүдийн сургамж, зөвлөгөөний ачаар би бусдад нийцсэн ч нийцээгүй ч өөрөө өөрийгөө байгаагаар нь хүндэлж, үнэлж, сайн харж мэдэрч явах хэрэгтэй гэдгийг ухаарсан. Мөн надад ч Буддагаас заяасан бурханлаг мөн чанар байдаг гэдгийг мэдэж, бурханлаг чанараа улам гялалзуулан авч явахын төлөө өдөр бүр зүтгэн амьдарч байна.

Одоо би Цагаан Лянхуа Цэцгийн судрыг маш сонирхон сурч байгаа. Бас лидерын үүргийн тухай сурч, ном уншлагаа ч өдөр бүр хийж байгаа. Өдөр бүр, цаг бүр буддын сургаалыг туршин биелүүлэхийг бодож байгаа. Үүсгэн Байгуулагч, Мёко багш нар Цагаан Лянхуа Цэцгийн судрыг дэлхийд дамжуулан тараахын төлөө хамаг амьдралаа зориулсанд нь үнэхээр талархаж байна.

Би христос шашинтай найз нартаа өөрийгөө тэд нараас өөр замаар явж байгаагаа хэлж чадалгүй байсан боловч нийгэмлэгт элсээд хэдэн сарын дараа өөрийгөө буддист гэдгээ бусдад бахархалтайгаар хэлж чаддаг болсон.

Өдий хүртэл хамгийн их сэтгэл хөдөлсөн явдал бол 2011 оны 3 сарын 27-нд болсон хоза дээр болсон юм. Озна гуайгийн хуримын ёслолд Японоос зочид ирж, ням гаригийн мөргөлд оролцон ирсэн билээ. Тэр өдөр Японд

болсон их газар хөдлөлт, цунамигаас дөнгөж хэдхэн долоо хоног өнгөрч байсан ч бид бүгд хамтдаа инээж, уйлж өнгөрөөв. Бид хоорондоо ярилцахын тулд орчуулагч хэрэгтэй байсан ч тэр үед бид бүгд нэгэн “хүн” гэдгийг мэдэрсэн юм.

Түүнээс хойш ч олон сайхан дурсамж бий. Жишээлбэл, шашин шүтлэгийг давсан Японд үзүүлэх тусламжийн үйл ажиллагаа, бясалгалын цуглаан, оройн хоолны нийлэг, бас Кошё багш Америкт зочилсон үед болсон Оклахома нийгэмлэг дэх цуглаан гээд олон сайхан дуртгал бий. Сангагийн төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцсоноор би РКК-н дотор ч бусад шашны хүмүүстэй ч найз болсон. Өвчин маань ч арай гайгүй болсон. Энэ бол би өмнөхөөсөө илүү эелдэг сэтгэлтэй болсноос болсон байх.

Лидерийн хувьд би РКК-ийн сургаалыг америк хүмүүст дамжуулан зааж, салбарынхаа даргад бага ч гэсэн тус нэмэр үзүүлэх нь миний үүрэг гэж бодож байна. Энэ жил би Цагаан Лянхуа Цэцгийн судрыг улам сайн суралцаж, Үүсгэн Байгуулагчийн шашны даяаны үйл ажиллагааны тухай улам гүнзгий судалж мэдэх зорилготой байгаа. Үүнээс хойш ч би зөвхөн өөрийнхөө төлөө бус бас нийгэм, дэлхийн төлөө сургаалын замаар алхан явах санаатай.



Амьдралд хэрэггүй зүйл гэж байхгүй

Бид амьдрах хугацаандаа янз бүрийн үйл тохиолтой учирдаг.Тэдгээрийн нэгэн ч оргүй хоосон зүйл биш юм.

Шагжамүни нь “амьдрал бол зовлон” гэж хэлсний дагуу хүний амьдрал зовлонтой байдаг.Тэгсэн ч,бид үнэхээр зовлон бэрхшээлтэй учрахдаа “яагаад заавал би вэ?”гэж гомдлон,үгээ бардаг билээ.Гэвч тэдгээр зовлонг туулж үзэхгүй л бол амьдралын жинхэнэ баяр баясгаланг амсаж чадахгүй юм.Зовлонг даван туулах гэсэн үйл дотор жинхэнэ баясал хөөр байдаг байна.

Хүн өөрийн бие сэтгэлээр өвчин зовлон,эдийн засгийн дампуурал гэх мэтийн зовлон үзэж байж л өөртэй адил зовлонтой хүмүүст зовлонгоо дийлэх арга зам,даваж туулсны дараах баяр баясгаланг итгэлтэйгээр ярьж зааж чадах билээ.

Зовлонтой учирсан үед “Будда багш минь энэхүү зовлонгоор минь надтай адил зовж буй хүмүүсийг аварч туслах хүч чадал өгөөсэй”гэж бодож хүлээн авч чадвал өөрийн дотор хүч эрчим гарахыг анзаарах болно.

“Хэрэггүй зүйл нь чухал байдаг”гэсэн үг байдаг билээ.Амьдралд тохиолдох янз бүрийн үйл явдал,зовлон бэрхшээл,хий дэмий гэж бодсон үйл нь бүгд ирээдүйн төлөө байдаг байна.

Үүсгэн Байгуулагчийн Үг 5 (Kosei Publishing Co.), 94-95x

Information Aug. 2011

For the prayer for the victims and survivors of the Eastern Japan Earthquake and Tsunami, see next page.


C O L U M N

Япон судлалын нэрт эрдэмтэн доктор Сарож Кумар Чаодори нь 6 сарын 27-нд Японд ирлээ.Тун удалгүй Цагаан Лянхуа Цэцэгийн судар нь бэнгал хэл дээр орчуулагдан гарна.Чаодори доктор нь Японд тун элэгсэг бөгөөд манай оронд арван хэдэн жил амьдарсан байна.Тэрээр зөвхөн Японд элэгсэг биш бас буддын шашинд маш няхуур ханддаг нэгэн билээ.Тиймээс ч, Чаодори доктор нь хичнээн өдийгээр 80 гарсан өндөр настай ч орчуулгын ажлаа гүйцээхийн тулд зориулж Японд ирсэн байна.Түүний Цагаан Лянхуа Цэцэгийн судрын орчуулганд зарцуулах идэвх,чармайлтыг хараад би өөрийн эрхгүй дуу алдсан билээ.Дээр үед Хятадад буддын сударыг орчуулахын төлөө улсаас ихээхэн хөрөнгө гаргаж,хэдэн арван мянга гаруй тооны лам нар орчуулгын ажилд оролцож байсан гэдэг.Мундаг сайн орчуулагч нар ч байсан юм.Гэсэн ч улс төр нь хэдий их мөнгө зарцуулсан ч тэдгээр хүмүүсийн идэвхтэй,бие сэтгэлээ дайчилсан хөдөлмөр байгаагүй бол бүтэхгүй байсан байх.Бид бол эрдэм,мэдлэгтэй,бас идэвхтэй эрчимтэй Чаодори доктортой учирч чадлаа.Бэнгал хэл дээрх Гурван Эрдэний Судар тун удахгүй гүйцэх гэж байна.

ОУХ-ийн дарга Катори Сүзүки

Рисшо Косей Кайгийн тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Нивано Никкё болон Наганума Мэко нарын санаачилгаар үүсэн байгуулагдсан юм. Манай байгууллага нь “Лянхуа цэцгийн гурван судар”-ыг номлолынхоо эх үүсвэр болгож, гэр бүлээрээ шүтэх шашны нэгэн шинэ хэлбэр бөгөөд сургааныг амьдрал ахуй, нийгэмд хэрэгжүүлж аз жаргалтай амьдрал, тэгээтэй нийгэм, дэлхийн энх тайвныг зорьдог юм.



SHAN-ZAI Volume 71 (August 2011)

[Эрхлэн гаргагч] Рисшо Косей Кай Сургаал дэлгэрүүлэх олон улсын төв. Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo, 166-8537 Japan, TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224, E-mail : shanzai@kosei- kai.or.jp

※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Солонгос хэл дээр тогтмол хэвлэгдэн гардаг бөгөөд зарим дугаар нь бусад орны хэл дээр ч хэвлэгдэн гардаг. ※Санал, сэтгэгдэл байвал бидэнтэй холбоо барина уу. ※ Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын салбартай холбоо барина уу.

**A Memorial Service for the Spirits of
the Victims of the Eastern Japan Earthquake and Tsunami
and a Prayer for the Recovery of the Survivors and Their Communities**

- Homage *(Chant the O-daimoku three times)*
- Meditation on the Place of the Way
- Taking Refuge in the Three Treasures
- Invocation

We put our faith in

The Eternal Buddha Shakyamuni—Great Benevolent Teacher, World-honored One;

The Tathagata Abundant Treasures, witness to the Lotus Sutra;

The emanations of the Buddha in the ten directions in the past, present, and future;

The four Great Bodhisattvas: Superior Practice, Boundless Practice, Pure Practice, and Steadfast Practice;

The Bodhisattva-Mahasattvas: Manjushri, Universal Wisdom, Maitreya, and all other Bodhisattva-Mahasattvas;

Great Bodhisattva Nichiren, revered practitioner of the Lotus Sutra;

Founder Nikkyo, Great Teacher of the One Vehicle;

Cofounder Myoko, Bodhisattva of the Way of Compassion;

The guardian spirits of Rissho Kosei-kai;

And the countless heavenly spirits in the ten directions.

May you all be present among us and know our deep devotion.

We members of Rissho Kosei-kai, all of pure heart, gather together to conduct this sincere memorial service for the spirits of the victims of the Eastern Japan Earthquake and Tsunami, and offer our heartfelt prayers that the survivors will quickly recover and rebuild their communities.

Here, we reverently pray that the spirits of

***Ji-sei-in-ho-myo-an-higashi-nihon-daishinsai-toku* several thousand more than
twenty thousand persons, including men and women, boys and girls**

will delight in the taste of the Dharma through the sutra recitation of this memorial service.

We further pray that the suffering people's lives will return to normal and that their communities will recover smoothly.

We earnestly pray for guidance in all things through the merit we receive from reciting the Great Vehicle Sutra of the Lotus Flower of the Wonderful Dharma.

(Strike the gong and chant the O-daimoku once)

- Opening Verse
- Sutra Recitation
- Universal Transfer of Merit
- Chanting the O-daimoku
- Transfer of Merit

Having respectfully recited the Great Vehicle Sutra of the Lotus Flower of the Wonderful Dharma, may we transfer its merits to and thus reciprocate the boundless compassion of

The Eternal Buddha Shakyamuni—Great Benevolent Teacher, World-honored One,

The Tathagata Abundant Treasures, witness to the Lotus Sutra;

The emanations of the Buddha in the ten directions in the past, present, and future;

The four Great Bodhisattvas: Superior Practice, Boundless Practice, Pure Practice, and Steadfast Practice;

The Bodhisattva-Mahasattvas: Manjushri, Universal Wisdom, Maitreya, and all other Bodhisattva-Mahasattvas;

Great Bodhisattva Nichiren, revered practitioner of the Lotus Sutra;

Founder Nikkyo, Great Teacher of the One Vehicle;

Cofounder Myoko, Bodhisattva of the Way of Compassion;

The guardian spirits of Rissho Kosei-kai;

The guardian spirits of Rissho Kosei-kai ();

The guardian spirits of member families of Rissho Kosei-ka;

And the countless heavenly spirits in the ten directions.

(Strike the gong once)

Now, we have conducted a sincere memorial service for the spirits of the victims of the Eastern Japan Earthquake and Tsunami, and we have offered our heartfelt prayers that the survivors quickly recover and rebuild their communities.

We reverently offer and transfer the merits of this recitation to the spirits of

Ji-sei-in-ho-myo-an-higashi-nihon-daishinsai-toku several thousand more than twenty thousand persons, including men and women, boys and girls

so that they may delight in the taste of the Dharma and quickly accomplish the wonderful fruit of supreme enlightenment through the sutra recitation of this memorial service.

We respectfully pray and ask that you extend your hand of compassion and sympathy through your divine communication with us, so that profound guidance and protection may be given for the recovery of the disaster areas.

- Homage

(Chant the O-daimoku three times)